



“ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Цалин хөлс, нэмэгдэл шинэчлэн
тогтоох тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/392 дугаар захирамж, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ, төвлөрсөн хогийн цэгүүдийн хүнд нөхцөлд ажиллаж буй ажилтан албан хаагчдын цалин, нэмэгдлийг нэгдүгээр хавсралтаар, бусад ажилтан албан хаагчдын цалинг 50 хувиар нэмэгдүүлж, нэмэгдлийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Шинэчлэн тогтоосон цалин, нэмэгдлийг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож олгохыг Хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (М.Оюунсүрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2024 оны А/16 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, А/22 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтэс (Ц.Очироо)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХЦЭЦЭГ

1360010382

C:\2024\A тушаал.docx